

НОГООН БАРИЛГА

Ногоон барилга гэдэг нь архитектурын салбарт сүүлийн үед бий болж буй чиг хандлага бөгөөд хүрээлэн буй орчинд ямар ч хоргүй, цахилгаан эрчим хүчний хэрэглээ бага, экологид ээлтэй барилга байгууламж юм. Ногоон барилга нийгэмд ашиг тустай төдийгүй яваандаа барилга байгууламжид тавих гол шалгуур үзүүлэлт, стандарт болох аж.

Ногоон барилга нь барилга барьж эхлэхээс ашиглалтад орсны дараах бүхий л хугацааг хамарсан ойлголт. Хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй байх, нөөцийг үр ашигтай ашигласан байх, барилгын ажлын төлөвлөлт, архитекторын шийдэл хийхээс эхлээд барилгыг барих үйл явц, ашиглаж буй барилгын материал, барилгын дотоод, гадаад орчин зэргийг бүхэлд нь цогцоор нь авч үздэг.

“Ногоон барилга” гэж төслийн байршил сонголт, төлөвлөлт, угсралт, ашиглалт, засвар үйлчилгээ, сэргээн босголт, нураах гэсэн барилгын амьдралын мөчлөгийн бүхий л үе шатанд хүрээлэн буй орчиндоо хариуцлагатай, байгалийн нөөцийн хэмнэлттэй барилга байгууламжууд юм.

‘Ногоон’ барилга нь зураг төсөл, барилга угсралт, ашиглалтын явц дахь сөрөг нөлөөллийг бууруулж, арилгаж, эерэг нөлөөллийг бий болгож чадах барилга байгууламж юм. Ногоон барилгууд байгалийн үнэт баялгийг хадгалан үлдэж, бидний амьдралын чанарыг сайжруулдаг билээ. [World Green Building Council](#)-н үзэж буйгаар барилгыг ‘ногоон’ болгох хэд хэдэн онцлог шинж чанарууд байдаг. Үүнд:

- Эрчим хүч, ус болон бусад нөөцийг үр ашигтай ашиглах
- Нарны эрчим хүч зэрэг сэргээгдэх эрчим хүчийг ашиглах
- Бохирдол, хог хаягдлыг бууруулах арга хэмжээ, дахин ашиглах, дахин боловсруулах боломжийг олгох
- Гэр доторх орчны агаарын чанар
- Хоргүй, ёс зүйтэй, байгальд ээлтэй материалыг ашиглах
- Дизайн, барилга байгууламж, ашиглалтад хүрээлэн буй орчныг харгалзан үзэх
- Дизайн, барилга байгууламж, ашиглалтын үеийн оршин суугчдын амьдралын чанарыг харгалзан үзэх
- Өөрчлөгдөж буй орчинд дасан зохицох боломжийг олгодог загвар

Бидний амьдарч, ажиллах барилга байгууламж эдийн засгийн буюу нөөцийн хувьд үр ашигтай, хэмнэлттэй байх, ашиглах хугацаа харьцангуй урт, тав тухыг хангасан байх нөхцлийг ногоон барилгын үзэл баримтлал чухалчилдаг. Гэхдээ улс орон, бүс нутаг нь цаг уурын өвөрмөц байдал, өвөрмөц соёл, уламжлал, барилга байгууламжийн төрөл, нас, байгаль орчин, эдийн засаг, нийгмийн өргөн цар хүрээ гэх мэтээс шалтгаалж улс орон бүр дэх ногоон барилга байгууламж харилцан адилгүй байдаг.

Ийм учраас экологид ээлтэй ногоон барилгуудыг шалгаруулж дэмждэг байгууллагууд хүртэл бий болжээ. “HowStuffWorks” нь барилга барих арга барилд олон жил ноёрхсон стандартыг халж ногоон технологиор бүтээсэн барилга байгууламж барих санал санаачлагыг дэмждэг байгууллага юм. Түүнчлэн Америкийн архитекторчдын хүрээлэн жил бүр ногоон технологиор бүтсэн шилдэг 10 ногоон төслийг тодруулдаг бол Америкийн ногоон барилгын зөвлөл, Эрчим хүч, экологийн тэргүүн төсөл зэрэг зорилго нэгтэй байгууллагууд бий.

Барилгын салбар дэлхийн нийт ДНБ-ний 10 хувь, хүлэмжийн хийн ялгаруулалтын 23 хувийг эзэлдэг ба материалын урсгалын 30-40 хувь нь энэ салбарт ногддог гэсэн судалгаа байдаг. Иймд, ногоон барилгын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх нь барилга, байгууламжийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулах, нөөц баялагийг илүү үр ашигтай зарцуулах боломжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үздэг.

Ногоон барилга нь барилга барих, түүнтэй холбоотой арга барил, техник, ур чадварыг өөртөө багтаасан байдаг тул эрчим хүчний хэрэглээн дэх сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх, эрчим хүч, ус хэмнэх, дулааны алдагдлыг бууруулах, хэмнэлтийн шийдэл бүхий технологи ашиглах, түүний дотор бор, цасны ус болно саарал ус ашиглах шийдэлтэй байх, стандартаар тогтоосон ногоон байгууламжтай байх шаардлагыг хангасан байх, тээврийн хэрэгслийн зогсоолын хангалттай шийдэлтэй байх, ашигласан барилгын материал нь нэгд, хүний эрүүл мэнд, хоёрт, байгаль орчинд сөрөг нөлөө багатай, түүний зэрэгцээ уламжлалт хөнгөн бетон, асфальт хэрэглэхээс илүүтэй ус нэвчих бетон эсхүл багцалсан хайрга ашигласан байх зэрэг шаардлагыг хангасан байх ёстой байдаг.



Өнөөгийн нийгэмд дараах үндсэн гурван шаардлагын улмаас «Ногоон барилга»-ын хэрэглээ зайлшгүй чухлаар тавигдах болсон. Үүнд:

- Хүрээлэн буй орчны өөрчлөлт, байгалийн нөөцийн хомсдол

Ногоон барилга төлөвлөж, барьж байгуулан хэрэглэх нь хүрээлэн буй орчны өөрчлөлт, байгалийн нөөцийн хомсдолын асуудлуудыг ёс зүйн болон хэрэглээний үүднээс зохистойгоор шийдвэрлэж буй явдал юм. Маш сайн ажиллагаатай «Ногоон барилгууд» нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр хэрэглэдэг, ус болон барилгын материалуудыг дахин хэрэглэх боломжтой, байгалийн болон хүний гараар бүтсэн ногоон байгууламж бүхий, бие даасан халаалт, агаар сэлгэлтийн системтэй байна.

- Эдийн засгийн үр ашигтай байдал

Ногоон барилгын төлөвлөлт, барилга угсралтын ажлын анхны санхүүжилт өндөр байх нь элбэг тохиолдох хэдий ч барилгын урт хугацааны ашиглалтын зардал харьцангуй бага байх давуу талтай. Жишээ нь ундны хэрэглээнээс бусад ахуйн болон усалгааны хэрэгцээнд зориулсан борооны ус цуглуулах систем нь нэмэлт хоолой, ус нөөцлөх сан, шүүлтүүр, тунгаагуур зэрэг технологи, эдлэхүүнүүд шаарддаг боловч барилгын ашиглалтын явцад тэдгээр хэрэглээнүүдэд зориулж цэвэр ус боловсруулах зардлыг тодорхой хувиар бууруулдаг. Хамгийн оновчтой шийдлүүдийг тусгасан ногоон барилга нь анхны санхүүжилт, зардлаа харьцангуй богино хугацаанд ч нөхөх боломжтой.

- Барилгын эрүүл ахуй, хэрэглэгчийн эрүүл мэнд

Оновчтой төлөвлөлттэй ногоон барилга (тогтвортой барилга) нь барилгын үр ашигтай ажиллагаагаар дамжуулан орон зайн хэрэглэгч болох хүний эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлдэг.

1984 оны Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (World Health Organization) -ын судалгааны тайланд дэлхий дахины хэмжээнд шинээр баригдсан болон дахин сэргээн засварласан нийт барилгын 30 хувь л эрүүл ахуйн шаардлага хангасан дотор агаарын орчин бүрдүүлж буйг тогтоосон байдаг. Үлдсэн хувь буюу эрүүл ахуйн шаардлага хангаагүй дотор агаарын орчин бүрдүүлсэн барилгуудад ажиллаж, амьдардаг хэрэглэгчдийн биеийн дархлаа буурах, хууч өвчлөл сэдрэх, хөдөлмөрийн бүтээмж буурах зэрэг барилгаас үүдэлтэй өвчлөл нэмэгдэх, улмаар жил бүр эмчилгээний зардалд 150 тэрбум ам доллар зарцуулж байгааг тогтоосон байдаг.

- Ногоон барилгад тавигдах шаардлага:

- Барилгын амьдралын мөчлөгийн тооцоо ба үнэлгээтэй /байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө бага/
- Үр ашигтай төлөвлөлт
- Ашиглалтын үед ус болон эрчим хүчний хэмнэлттэй
- Тогтвортой материал ашигласан
- Дотор агаарын чанарын шаардлага хангасан
- Барилга угсралтын үеийн хог хаягдал бага,
- Буулгасны дараа гарсан материалыг дахин ашиглах боломжтой гэх мэт.

Ногоон барилга төлөвлөхөд дараах үндсэн зарчмуудыг баримтална. Үүнд:


- Барилгын талбайг оновчтой сонгох: Тогтвортой барилга төлөвлөхдөө орон нутгийн

экоосистемд үзүүлэх нөлөө, зорчил, хөдөлгөөн хийх боломж, эрчим хүчээр хангах нөхцөл зэргийг тооцож, барилгын талбайг зөв сонгохоос эхлэх ба улмаар барилга байршуулах, зүг чигийг зөв тогтоох нь чухал юм.

- Барилгын эрчим хүчний хэмнэлтийн зарчим: Тогтвортой барилга нь сэргээгдэх эрчим хүчээр хангагдах боломжтой, эрчим хүчний хэрэглээ стандартад заасан хэмжээнд, түүнээс илүү хэмнэлттэй байх.
- Усны хэрэглээ: Дэлхий нийтээрээ ундны усны нөөцийн хомсдолд орж буй өнөө үед тогтвортой барилга төлөвлөхдөө ус хэмнэх, үр ашигтай зарцуулах, дахин ашиглах буюу саарал ус ашиглах боломжтой байдлаар төлөвлөдөг.
- Зөв төлөвлөлт: Барилгын хаших бүтээцийг зөв төлөвлөх, дулаан хамгаалалтын тооцооны программыг ашиглах, барилгын масс ба дулааны алдагдлын гүүрийг зөв тооцох, ногоон барилгын материал ашиглах, барилгын норм ба дүрэм, стандартуудыг баримтлах нь чухал юм.
- Дотор агаарын чанар: Барилгын дотор агаарын чанар нь хүний эрүүл мэнд, тав тухтай байдал, хөдөлмөрийн бүтээмжид хамгийн чухал хүчин зүйл байдаг. Дотор агаарын чанарт тавигдах нийтлэг шаардлагаас гадна чийгийн хяналт, агаар сэлгэлтийн зохистой ажиллагаа, байгалийн гэрэлтүүлэг зэргийг мөн авч үзэх хэрэгтэй.
- Одоо байгаа барилгуудад судалгаа хийх: Ихэнх тохиолдолд хуучин барилгуудыг судалж, одоогийн нөхцөлийг үнэлсний үндсэн дээр талбайг дахин сэргээх, барилга байгууламжийг сэргээн засварлах эсвэл шинээр барих нь оновчтой юм.
- Хэрэглээ ба ашиглалтын менежментийг зөв хийх гэх мэт

ЯАГААД БИД НОГООН БАРИЛГА БАРИХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Барилга байгууламж барих, ашиглалтын явцад дэлхийн эрчим хүчний хэрэглээний 36 хувийг хэрэглэж, дэлхийн хүлэмжийн хийн 39 хувийг бүрдүүлдэг.



IEA and UNEP. 2019. 2019 Global Status Report for Buildings and Construction. Pg. 12;
and Levin, K. Dec. 5, 2018. New Global CO2 Emissions Numbers Are In. They're Not

ЯАГААД БИД НОГООН БАРИЛГА БАРИХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Барилгын эрчим хүчний хэрэглээ 2035 он гэхэд 37 хувиар өсөх төлөвтэй байна.


Энэ өсөлтийн 96 хувь нь хөгжиж буй орнуудад бий болно гэж таамаглаж байна.



ЯАГААД БИД НОГООН БАРИЛГА БАРИХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Барилгын салбар нь дэлхийн эдийн засагт орж ирж буй байгалийн материалын 40 хувийг хэрэглэдэг.

% MATERIALS USED IN THE BUILDINGS



ЯАГААД БИД НОГООН БАРИЛГА БАРИХ ХЭРЭГТЭЙ ВЭ?



RESOURCE SHORTAGE



CLIMATE CHANGE



RAPID URBANISATION

1. Эрчим хүчний хэмнэлттэй

Барилгын хийцлэлийн хувьд дулааны алдагдал хамгийн бага байх, гэрэлтүүлэг болон бусад инженерийн том шугамнууд нь автомат байдлаар ажиллахаас гадна эрчим хүчний хэмнэлттэй, хэрэглээндээ таарсан байх хэрэгтэй. Энэ чиглэлд орчин үеийн шинэ техник, технологи болон BIM, BMS гэх мэт программ хангамжууд маш олон боломж олгож байна.

- BIM буюу “building information model” программыг ашиглан барилгын зураг төсөл төлөвлөлтөөс эхлүүлэн барихаасаа өмнө барилгын үр ашгийг тооцох хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Барилгыг 3D, 4D, 5D хэмжээсээр байгуулж, хугацаа, зардал, эргономик, үр ашигтай байдал гээд барилга амжилттай баригдах бас баригдсаны дараа тогтвортой, үр ашигтай, аюулгүй оршин байхтай холбоотой бүхнийг урьдчилан харж, тооцож, туршиж, судалдаг программ хангамж.
- BMS буюу “building management system” нь барилга, хөрөнгийн менежментийн программ хангамж юм. Дээрхтэй ижлээр барилга баригдсаны дараах ашиглалттай холбоотой зардлыг бууруулах, хянах зорилго бүхий хэрэглээ, ашиглалтыг ухаалгаар удирдан зохицуулах үүрэгтэй. Барилгын сан, цахилгаан, дулаан, холбоо дохиолол, агааржуулалтын систем гээд бүгдийг ухаалгаар нэгдсэн журмаар удирдана. Тухайн барилгад тохирсон “building management system”-ийг загварчилж, зөв ашиглаж чадвал ашиглалтын зардлыг 50 хүртэл хувиар бууруулах боломжтой.

2. Усны хэмнэлттэй байх

Ногоон барилгын сертификат олгодог олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудаас ногоон барилгад усны хэмнэлт доод тал нь 20-30 хувь байхыг шалгуураа болгодог. Сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий ухаалаг суултуур, далд бочки, холигч, шүршүүр зэрэг сантехникийн тоноглолууд нь усны нөөцийг хэмнэх боломж олгож байна.

3. Сэргээгдэх эрчим хүч ашигласан байх

Монгол орны хувьд сэргээгдэх эрчим хүчний дараах төрлүүд байна.

- Нарны эрчим хүч
- Газрын гүний дулааны эрчим хүч
- Салхины эрчим хүч
- Усны эрчим хүч

Монголд жилийн 270 гаруй өдөрт цэлмэг байна гэж тооцоход нарны гийгүүлэх хугацаа жилд дунджаар 2250-3300 цаг байх юм. Энэ нь манай улсын нарны эрчим хүчний жилийн нөөц 4.8 их наяд кбайт цаг буюу нарны нөөц хамгийн ихтэй гурван орны нэг нь болж байгаа юм. Тиймээс сэргээгдэх эрчим хүчний сонголтуудаас манай оронд хамгийн тохиромжтой нь нарны зайн систем юм.

4. Дотор агаарын чанар

Барилга доторх агаар сэлгэлт, цэвэршүүлэлт, хөргөлтийг шийдвэрлэсэн буюу агааржуулалтын системтэй байх шалгуурыг хангасан байх учиртай. Өөрөөр хэлбэл агаарын чанар хэт халуун эсвэл хүйтэн, хуурай биш байснаар хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй байх ба барилгад суурьлагдсан системүүд нь төхөөрөмжүүдтэйгээ холбогдож, ухаалгаар ажилсанаар хүний ажиллаж амьдрах тав тухтай орчныг бүрдүүлэх юм.

5. Тохиромжтой эргономик шийдэлтэй байх

Барилгын зураг төсөл гаргахдаа хүний ажиллаж, амьдрах тав тухтай орчин нөхцөл, нөөц бололцоог тооцоолон өрөөний зохион байгуулалт, барилгын орц гарц, явган хүний зам, ерөнхий

төлөвлөлтөд зөв тусгасан байх шаардлагатай. Жишээ нь шатны гишгүүрийг буруу тооцоолж хийснээс болж хүн бүдрэх, яваандаа үе мөч нь өвдөх, улмаар гэмтэх эрсдэлтэй.

6. Эко барилгын материал ,технологи ашигласан байх

Барилгад ашигласан материалууд хорт бодис, хүнд металлын агууламжгүй, барилга доторх хүмүүсийн эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхээргүй байх гэсэн шаардлага тавигддаг. Жишээ нь: тавилгын хавтан гэхэд л түүхий эд нь байгалийн гаралтай, дагалдах цавуу зэрэгт хүний биед сөрөг үйлчилгээтэй бодис агуулагдаагүй байх ёстой. Түүнчлэн тухайн материалын үйлдвэрлэл нь байгальд ээлтэй, хүлэмжийн хий ялгарлыг нэмэгдүүлдэггүй байх ёстой. Гэвч байгалийн гаралтай түүхий эдээр бүтсэн, ус болон эрчим хүчний хэмнэлттэй эко материал энгийн материалаас 20-30 хувь илүү үнэлгээтэй байдаг нь орон сууцны өртөг, үнэлгээнд нөлөөлж байна.

7. Стандартаар тогтоосон ногоон байгууламжтай байх

Барилга нь өөрөө хүний эрүүл мэндээс гадна байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх ёстой. Орчиндоо бохирдол, хог хаягдал үүсгэдэггүй байх болон ногоон байгууламж, ногоон дээврийг зохих хэмжээнд зөв төлөвлөсөн байх ёстой. Ногоон дээвэр гэж ярих болсон нь ногоон байгууламж хийх хангалттай газаргүй бол барилгынхаа дээвэр дээр хийхийг зарим улс орнуудад журамлах болсон. Жишээ нь, Сингапурт барилгын 30%-иас багагүй талбайд ногоон байгууламж байх ёстой гэсэн шаардлага тавьдаг.

Ногоон барилгын үзэл баримтлал энэхүү дэлхийн дулаарал хүн төрөлхтөний анхаарлыг татаж эхэлсэн үетэй цаг хугацааны хувьд шууд холбогддог.

Ногоон барилга нь барилга барьж эхлэх, түүний ашиглалтанд байх бүхий л хугацааг хамарсан ойлголт бөгөөд хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй байх, нөөцийг үр ашигтай ашигласан байх, барилгын ажлын төлөвлөлт, архитекторын шийдэл хийхээс эхлээд барилгыг барих үйл явц, ашиглаж буй барилгын материал, барилгын дотоод, гадаад орчин зэргийг бүхэлд нь цогцоор нь авч үздэг.

Бидний амьдарч, ажиллах барилга байгууламж эдийн засгийн буюу нөөцийн хувьд үр ашигтай, хэмнэлттэй байх, ашиглах хугацаа харьцангуй урт, тав тухыг хангасан байх нөхцлийг ногоон барилгын үзэл баримтлал чухалчилдаг.

8. Ногоон барилгын ач холбогдол

- Эдийн засгийн хувьд:

Зардал хэмнэх, активын чанарыг дээшлүүлэх, үр ашгийг өсгөх

- Нийгмийн хувьд:

Амьдарч, ажиллаж буй хүмүүсийн эрүүл мэнд, тав тухыг хангах, амьдралын чанарыг сайжруулах

- Байгаль орчны хувьд:

Агаарын бохирдол, хог хаягдлыг бууруулах, ус хэмнэх, ундны усны чанарыг сайжруулах, байгалийн баялаг, нөөцийг ариг гамтай зарцуулах, хэмнэх

- Засаглалын хувьд:

Компаний нийгмийн хариуцлага өндөржүүлэх

9. Ногоон барилгын концепцыг хэрэгжүүлснээр гарах үр дүн

- Ой мод, ус, бусад байгалийн баялагаа хэмнэж чадна
- Байгаль орчны тогтвортой байдалд хувь нэмрээ оруулна.
- Агаарын бохирдол буурна
- Хүн амын эрүүл мэндэд эерэг нөлөө үзүүлнэ
- Барилга, эрчим хүч, усны салбарт орчин үеийн дэвшилтэт технологи ашиглалт нэмэгдэнэ
- Компаний нийгмийн хариуцлага сайжирна





Инновац

Шинэлэг шинж чанар,
журмыг нэвтрүүлэх



Дотоод Агаарын Чанар

Байгалийн гэрлийг
ашиглах, үр ашигтай
агааржуулах



Материал болон Байгалийн Нөөц

Хариуцлагатай
барилгын хог хаягдлын
менежмент, материалын
тогтвортой эх үүсвэр



Байршил ба Тээвэр

Газар нутгийг хамгаалах,
нийтийн тээврийн хэрэгсэлд
ойр байх, 'ногоон' тээврийн
хэрэгсэл ашиглах: дугуй,
скүүтер гэх мэт...



Тогтвортой сайтууд

Хангалттай ногоон
задгай талбайтай байх,
гэрлийн бохирдлыг
бууруулах



Эрчим хүч ба уур альсгал

Тогтвортой эрчим
хүчний үйлдвэрлэл,
хяналт, тоолуурыг
оновчтой болгох



Усны хэртнэлт

Дотор ба гадна усны
хэрэглээг хэмнэх,
бууруулах

Ногоон барилгын үр өгөөж

Эрчим хүч, байгалийн нөөцийн ашиглалт болон нүүрстөрөгчийн хийн ялгаралтыг бууруулдаг гол онцлогтой.



25%

бага эрчим хүчний
зарцуулалт*

11%

бага усны
зарцуулалт*

78 сая

тонн CO2 ялгаруулалтаас
зайлсхийх

80 сая

тонн хог хаягдлыг дахин
боловсруулдаг*

Үйл ажиллагааны зардлын хуримтлалаас санхүүгийн өгөөжийг бий болго!

Дэлхийн үл хөдлөх хөрөнгийн тогтвортой байдлын жишгээс харахад эрчим хүчний хэмнэлттэй олон нийтийн барилгад дараах давуу талууд ажиглагдсан.

- Худалдах үнийн дүн 15 - 37% -иар өснө
- 8 - 35% түрээсийн хувь хэмжээг нэмэгдүүлсэн
- Ногоон барилга сонгох нь 9 - 18% нэмэгддэг
- Үйл ажиллагааны зардал 30% -иар бага байна
- Үйл ажиллагааны цэвэр орлого 9% -иар өндөр байна



Аз жаргалтай ажилчид, аз жаргалтай
оршин суугч, хэрэглэгчид

Ногоон барилгын гэрчилгээтэй орон зайд ажил олгогчид ажилтан ажилд авах, ажлын байрыг хадгалах түвшин өндөр байгаа, мөн дотоод орчны агаарын чанар, тав тухыг сайжруулснаар ажилчдын бүтээмж нэмэгддэг нь судалгаагаар нотлогдсон байдаг.

* Дахин - Ногоон барилгын гүйцэтгэлийг үнэлэх: 22 GSA барилгын ажлын байрны дараах үнэлгээ. Ким М. Фаулер, Эмили М.Рауч, Жордан В.Хендерсон.



НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолоор Ногоон хөгжлийн бодлогыг баталсан бөгөөд энэхүү тогтоолоос ногоон барилгын төлөвлөлттэй хамаарах хэсгүүдийг энд дурдлаа.

Хүснэгт - Ногоон хөгжлийн бодлогын нэр томъёоны жагсаалт

Нэр томъёо	Тодорхойлолт
Ногоон хөгжил	Байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай ашигласан, экосистемийн үйлчилгээг тэтгэсэн, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, нийгмийн оролцоог хангаж ядуурлыг бууруулах хөгжлийн загварыг
Ногоон эдийн засаг	Байгаль орчны эрсдэл, доройтлыг багасгахын зэрэгцээ хүний сайн сайхан байдал, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилго бүхий эдийн засгийг
Ногоон үйлдвэрлэл	Эрчим хүч, нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд эрсдэлгүй үйлдвэрлэлийн үйл ажиллагааг
Ногоон ажил	Эрчим хүч, түүхий эд материал, усны хэрэглээг багасгах, хүлэмжийн хийн ялгарлыг хязгаарлах, хог хаягдал, бохирдлыг бууруулах, экосистемийг хамгаалж нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох замаар хүрээлэн байгаа орчны чанарыг сайжруулж, хамгаалахад чиглэсэн ажил хөдөлмөрийг
Ногоон хот	Эрчим хүч, дулаан, ус хангамж, харилцаа холбоо, нийтийн тээврийн ухаалаг дэд бүтэц, хог хаягдлын оновчтой менежмент бүхий хүний амьдралын тав тух, хөгжлийн боломжийг хангасан хот сууриныг
Ногоон барилга	Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй материал ашигласан, дулааны алдагдал хамгийн бага байх хийцтэй, агаарт ялгаруулах хаягдал багатай халаалтын шийдэлтэй, эрчим хүч, нөөцийн хэмнэлт үр ашигтай, хур тунадасны усыг хуримтлуулж ашиглах, хаягдал бохир усаа цэвэрлэж зайлуулах технологи бүхий, тав тухтай орчныг бүрдүүлсэн барилга байгууламжийг
Ногоон худалдан авалт	Эрчим хүч, байгалийн нөөц баялгийн хэмнэлттэй хэрэглээ, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хангах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг
Ногоон санхүүжилт	Байгалийн нөөц баялаг, экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг хадгалж, эрчим хүч, түүхий эд материал, усны хэрэглээг багасгах технологи ашиглах төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх, тэдгээрт хөрөнгө оруулахыг

